**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

**Аудитын код: ОРА-2025/89/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Эрдэнэт хот<br>2025 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас:70353088, Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Буян-Ундрах<br>Утас: 70355805, Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn<br><br>Аудитор: Б.Азжаргал<br>Утас: 70357955, Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.17 № 03

танай______________-ны № _______________-т

СЭЛЭНГЭ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
М.ЧУЛУУНЗАГД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татаан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзэхээр байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 31.8 хувиар өссөн байна.

Энэ нь 2024 оны 03 сарын 27-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 128 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ”-г шинэчлэн тогтоож 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох журам"-г мөрдөж эхэлсэнтэй холбоотой байна.

Тус газрын батлагдсан төсвийн "Усны энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд орсон зориулалтын бус төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх" арга хэмжээний зардлаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/352 тушаалаар 126.2 сая төгрөгийг Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаанд шилжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Байгаль, орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулж, хэрэгжилтийг 88.4 хувьтай гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 33,861,500.00 | 295,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 33,861,500.00 | 295,000.00 |
| 351 | Түүхий эд материал | 33,041,500.00 | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 33,041,500.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 820,000.00 | 295,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 320,000.00 | 295,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 500,000.00 | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 312,740,205.47 | 316,286,835.58 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 312,740,205.47 | 316,286,835.58 |
| 392 | Биет хөрөнгө | 312,740,205.47 | 315,018,902.25 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 318,626,996.50 | 318,626,996.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (10,979,750.08) | (72,639,832.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 19,680,000.00 | 27,023,300.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (15,735,999.40) | (2,360,526.71) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,715,092.66 | 18,400,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,566,134.21) | (188,888.92) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 33,041,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (6,883,645.90) |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 1,267,933.33 |
| 39301 | Програм хангамж | - | 1,267,933.33 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 346,601,705.47 | 316,581,835.58 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 346,601,705.47 | 316,581,835.58 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 346,601,705.47 | 316,581,835.58 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 346,601,705.47 | 316,581,835.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 346,601,705.47 | 346,601,705.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (30,019,869.89) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 346,601,705.47 | 316,581,835.58 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 632,641,792.00 | 890,101,065.38 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 312,610,468.32 | 61,452,733.33 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 312,610,468.32 | 61,452,733.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 312,610,468.32 | 61,452,733.33 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 311,903,218.32 | 60,652,733.33 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 707,250.00 | 800,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 320,031,323.68 | 828,648,332.05 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 240,280,000.00 | 734,313,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 240,280,000.00 | 734,313,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 79,751,323.68 | 94,334,732.05 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,651,323.68 | 61,282,732.05 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,800,000.00 | 32,252,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 300,000.00 | 800,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 327,597,251.78 | 887,079,435.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 327,597,251.78 | 887,079,435.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 322,611,202.66 | 829,227,235.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 199,943,528.82 | 300,936,711.79 |
| 210101 | Үндсэн цалин | 118,121,921.91 | 134,691,993.79 |
| 210102 | Нэмэгдэл | 57,409,618.91 | 115,428,018.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,642,300.00 | 31,562,300.00 |
| 210104 | Урамшуулал | 13,769,688.00 | 19,254,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,072,765.22 | 37,571,870.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,049,562.95 | 25,548,868.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,006,083.94 | 3,005,750.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,604,786.33 | 1,548,074.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 400,363.25 | 1,457,674.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,011,968.75 | 6,011,502.94 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,635,030.12 | 25,481,307.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,379,347.42 | 1,144,739.78 |
| 210302 | Түлш, халаалт | 1,239,682.70 | 1,176,568.14 |
| 210304 | Байрны түрээс | 12,016,000.00 | 23,160,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,988,290.00 | 31,496,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,994,800.00 | 875,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,130,640.00 | 28,740,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,227,850.00 | 1,401,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 635,000.00 | 480,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,300,000.00 | 6,396,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,300,000.00 | 6,396,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,346,600.00 | 12,533,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,346,600.00 | 12,533,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,989,110.40 | 336,473,192.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,952,800.00 | 335,982,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 126,750.00 | 77,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 204,560.40 | 226,372.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | 66,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,335,878.10 | 78,338,703.22 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 4,870,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,355,000.00 | 1,362,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,980,878.10 | 72,106,103.22 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,986,049.12 | 57,852,199.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 38,916,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 5,040,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 33,876,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,685,353.12 | 18,731,899.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,685,353.12 | 18,731,899.52 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 300,696.00 | 203,400.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,696.00 | 203,400.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 305,044,540.22 | 3,021,630.11 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 33,041,500.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 33,041,500.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (33,041,500.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 305,044,540.22 | (30,019,869.89) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 320,031,323.68 | 828,648,332.05 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 320,031,323.68 | 828,648,332.05 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 240,280,000.00 | 734,313,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 240,280,000.00 | 734,313,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 79,751,323.68 | 94,334,732.05 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,651,323.68 | 61,282,732.05 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,800,000.00 | 32,252,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 300,000.00 | 800,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 319,730,627.68 | 813,648,332.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 319,730,627.68 | 813,648,332.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 315,045,274.56 | 755,796,132.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 199,943,528.82 | 300,936,711.79 |
| 210101 | Үндсэн цалин | 118,121,921.91 | 134,691,993.79 |
| 210102 | Нэмэгдэл | 57,409,618.91 | 115,428,018.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,642,300.00 | 31,562,300.00 |
| 210104 | Урамшуулал | 13,769,688.00 | 19,254,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,072,765.22 | 37,571,870.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,049,562.95 | 25,548,868.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,006,083.94 | 3,005,750.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,604,786.33 | 1,548,074.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 400,363.25 | 1,457,674.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,011,968.75 | 6,011,502.94 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,635,030.12 | 25,481,307.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,379,347.42 | 1,144,739.78 |
| 210302 | Түлш, халаалт | 1,239,682.70 | 1,176,568.14 |
| 210304 | Байрны түрээс | 12,016,000.00 | 23,160,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,403,240.00 | 30,171,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,642,000.00 | 850,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,923,390.00 | 27,440,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,227,850.00 | 1,401,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 610,000.00 | 480,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,300,000.00 | 6,396,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,300,000.00 | 6,396,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,346,600.00 | 12,533,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,346,600.00 | 12,533,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,989,110.40 | 336,473,192.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,952,800.00 | 335,982,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 126,750.00 | 77,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 204,560.40 | 226,372.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | 66,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,355,000.00 | 6,232,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 4,870,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,355,000.00 | 1,362,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,685,353.12 | 57,852,199.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 38,916,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 5,040,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 33,876,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,685,353.12 | 18,731,899.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,685,353.12 | 18,731,899.52 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 203,400.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 203,400.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 300,696.00 | 15,000,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 15,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 15,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 15,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 15,000,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (15,000,000.00) |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 41,557,165.25 | 41,557,165.25 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 41,557,165.25 | 41,557,165.25 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 305,044,540.22 | 305,044,540.22 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 346,601,705.47 | 346,601,705.47 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 346,601,705.47 | 346,601,705.47 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 346,601,705.47 | 346,601,705.47 |

| | | | |
|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | (30,019,869.89) | (30,019,869.89) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 316,581,835.58 | 316,581,835.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 778,164,700.00 | 715,581,700.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 778,164,700.00 | 715,581,700.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 700,436,700.00 | 681,704,800.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 262,088,000.00 | 257,605,393.79 |
| 210101 | Үндсэн цалин | 139,174,600.00 | 134,691,993.79 |
| 210102 | Нэмэгдэл | 72,096,700.00 | 72,096,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,562,300.00 | 31,562,300.00 |
| 210104 | Урамшуулал | 19,254,400.00 | 19,254,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,760,500.00 | 32,155,456.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,277,300.00 | 21,865,706.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,620,800.00 | 2,572,437.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,355,600.00 | 1,331,418.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,265,200.00 | 1,241,018.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,241,600.00 | 5,144,877.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,000,000.00 | 25,481,307.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,800,000.00 | 1,144,739.78 |
| 210302 | Түлш, халаалт | 1,980,000.00 | 1,176,568.14 |
| 210304 | Байрны түрээс | 23,220,000.00 | 23,160,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,218,000.00 | 24,161,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 480,000.00 | 480,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,800,000.00 | 21,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,458,000.00 | 1,401,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 480,000.00 | 480,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 146,800.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 146,800.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 21,714,000.00 | 21,396,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 240,300.00 | - |
| 210602 | Тавилга | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 73,400.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,400,300.00 | 6,396,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,200,000.00 | 8,129,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,200,000.00 | 8,129,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 322,940,000.00 | 311,413,592.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 321,200,000.00 | 310,923,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 460,000.00 | 77,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 226,372.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 140,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 350,000.00 | 66,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,369,400.00 | 1,362,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,369,400.00 | 1,362,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 77,728,000.00 | 33,876,900.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 77,728,000.00 | 33,876,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 43,851,100.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 33,876,900.00 | 33,876,900.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 734,313,600.00 | 734,313,600.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 734,313,600.00 | 734,313,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 734,313,600.00 | 734,313,600.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 94,131,332.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 94,131,332.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 89,091,332.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 43,331,318.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,331,318.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,416,414.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,683,162.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 433,313.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 216,656.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 216,656.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 866,625.94 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,010,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 370,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,640,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,404,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,404,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,059,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,059,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,870,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,870,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,040,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,040,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 5,040,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 94,334,732.05 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 94,334,732.05 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,282,732.05 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,252,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 800,000.00 |

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,522.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 6,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3,522.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

**3.1 Төлбөрийн акт:**

Аудитаар төлбөрийн өгөгдөөгүй болно.

**3.2 Албан шаардлага:**

Илрүүлэлт: Тайлант онд 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**3.3 Зөвлөмж**

Илрүүлэлт: Тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 3,522.2 мянган төгрөгийг цалингийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь заалт “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна",Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Ангилал шинэчлэн батлах тухай" 190 дүгээр тушаалтай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Төсвийг зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдийн албан ёсны зөвшөөрлийг авах.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | орхигдуулсан | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сэлэнгэ голын сав газрын захиргаа | 2 | 9.5 | | | | | | | 1 | 6.0 | 1 | 3.5 |
| **Дүн** | **2** | **9.5** | | | | | | | **1** | **6.0** | **1** | **3.5** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сэлэнгэ голын сав газрын захиргаа | 2 | 9.5 | | | 1 | 6.0 | 1 | 3.5 | | | | |
| **Дүн** | **2** | **9.5** | | | **1** | **6.0** | **1** | **3.5** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | | | | | | | | |
| Сэлэнгэ голын сав газрын захиргаа | 1 | 6.0 | | | 1 | 6.0 | | |
| **Дүн** | **1** | **6.0** | | | **1** | **6.0** | | |
| **Нийт дүн** | **1** | **6.0** | | | **1** | **6.0** | | |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | 1 | | | |